Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын онцлог, санхүүгийн программтай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан-Уул аймгийн ЗДТГ 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13,180,960.7 мянган төгрөгөөр буюу 127.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	509,806.2	390,832.6	(118,973.6)
Урьдчилгаа	8,208.0	8,208.0	-
Бараа материал	204,838.0	32,736.2	(172,101.8)
Нөөцийн бараа	80,200.0	72,000.0	(8,200.0)
Үндсэн хөрөнгө	9,501,151.7	22,981,387.8	13,480,236.1
Нийт хөрөнгө	10,304,203.9	23,485,164.6	13,180,960.7
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	10,304,203.9	23,485,164.6	13,180,960.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	10,304,203.9	23,485,164.6	13,180,960.7

Авлага дансны үлдэгдэл 118,973.6 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь өмнөх оны нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулагдаагүй үлдэгдэл 509,806.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж авлага үүсгэсэн байсныг тайлант онд авч, мөн нэмэлт санхүүжилтийн данснаас улсын болон орон нутгийн төсвийн үлдэгдэл санхүүжилт 390,832.6 мянган төгрөгийг авлагаар тусгаж, 509,806.2 мянган төгрөг зарцуулсан нь бууралтад нөлөөлжээ.

Өмнөх онд аймгийн ЗДТГ-ын 2 давхрын коридорт захиалгаар хивс хийлгэхээр 8,208.0 мянган төгрөгийг “Натурал Текстайл Групп” ХХК шилжүүлж, урьдчилж гарсан зардлаар тайлагнасан боловч тайлант онд уг ажил хийгдээгүй байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 317,141.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, бусад эх үүсвэрээс 34,000.0 мянган төгрөгийн нөөцийн барааг үнэ төлбөргүй хүлээн авч, 380,080.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 148,363.0 мянган төгрөгийн мал амьтдыг Хонгор сумын ЗДТГ-т шилжүүлсэн нь бууралтад нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгө данс 13,480,236.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 169,107.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авч, УТХО болон ОНХС-ын хөрөнгөөр санхүүжсэн 14,715,207.6 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэлд авч, 1,404,079.1 мянган төгрөгийн элэгдэл тооцож, зардлаар хүлээн зөвшөөрсөн байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 23,485,164.6 мянган төгрөг болж 13,180,960.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 5,289,626.8 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 75,000.0 мянган төгрөг, нийт 5,364,626.8 мянган төгрөгийг бүрдүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсвийн төслийн саналыг 579,062.0 мянган төгрөгөөр нэмж, 5,943,688.8 мянган төгрөгөөр баталсан байна. Тодруулбал өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төрийн албан хаагчийн цалин болон бусад хууль эрхийн актад үндэслэн цалингийн зардлыг 869,979.3 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 108,747.6 мянган

төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 49,746.5 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 5,000.0 мянган төгрөг, хувийн хэвшлийн байгууллагуудад олгох татаасыг 18,000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс, төлбөр хураамжийн зардлыг 146,692.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 540,214.3 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 13,092.0 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлгийг 46,011.4 мянган төгрөгөөр тус тус бууруулжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд батлагдсан төсвийг 2,535,927.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Ингэхдээ байр ашиглалтын тогтмол зардлын тариф өссөн, шинэ байрны ашиглалттай холбоотойгоор уг зардлыг 275,000.0 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 10,000.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 291,500.0 мянган төгрөгөөр, томилт зочны зардлыг 30,000.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийг 18,900.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,731,327.5 мянган төгрөгөөр, хувийн хэвшилд олгох татаас 163,200.0 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийг 16,000.0 мянган төгрөгөөр тус тус нэмж, мэдээлэл сурталчилгааны зардлыг 5,000.0 мянган төгрөгөөр, харуул хамгаалалтын зардлыг 30,000.0 мянган төгрөгөөр бууруулсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 11 арга хэмжээг санхүүжүүлэхээр 8,404,616.3 мянган төгрөг буюу 99.1 хувийг орон нутгийн төсвөөс, 75,000.0 мянган төгрөг буюу 0.9 хувийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 7,395,320.3 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 37,373.3 мянган төгрөгийн орлого олжээ. Төсвийн зарлагын гүйцэтгэл 7,432,693.6 мянган төгрөг буюу 87.7 хувьтай бөгөөд зарцуулаагүй үлдсэн 604,580.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Үүнд цалингийн зардал 46,783.2 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн 19,848.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 492,678.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн 24,432.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 549,088.9 мянган төгрөг тус тус зарцуулагдаагүй үлдэж, туслах үйл ажиллагааны орлого 37,626.7 мянган төгрөгөөр дутуу биелсэн нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
А	"70106"-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	8,479,616.30	7,432,693.65	(1,046,922.65)	87.7
1	"80101"-Үндсэн үйл ажиллагааны зардал	3,655,031.30	3,212,706.30	(442,325.00)	87.9
2	"80103"-Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	931,089.20	901,527.08	(29,562.12)	96.8
3	"80205"-Мэдээлэл, сурталчилгааны зардал	15,000.00	15,000.00	-	100.0
4	"80508"- ТББ-д төсвөөс олгох дэмжлэг	201,114.00	195,520.70	(5,593.30)	97.2
5	"80802"- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	322,566.60	288,551.09	(34,015.51)	89.5
6	"81102"- Орон нутгийн нөөц хөрөнгө	973,163.70	814,627.20	(158,536.50)	83.7
7	"81507"-Мал тооллого	3,500.00	3,000.00	(500.00)	85.7

8	"81518"- Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх	2,287,151.50	1,914,593.28	(372,558.22)	83.7
9	"81549"-Ахмадын сан	16,000.00	16,000.00	-	100.0
10	"82309"-Дотоодын цэргийн хамгаалалт	25,000.00	21,168.00	(3,832.00)	84.7
11	"82801"- Улсын их баяр наадам	50,000.00	50,000.00	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэгдсэн судалгааны дүнгээр тус байгууллага Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу батлагдсан төсвөөс цалингийн сангийн 0.5 хувиар буюу 16,000.0 мянган төгрөгийг ахмадын санд төвлөрүүлэн, 16,000.0 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Тайлант онд бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний зардалд 134,631.0 мянган төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 110,198.5 мянган төгрөг зарцуулсан бол бараа үйлчилгээний бусад зардлаар 3,560,715.2 мянган төгрөг төлөвлөж, 3,011,626.2 мянган төгрөг зарцуулсан нь Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэх тогтвор суурьшилтай ажиллаж байгаа багш нарт орон сууцны дэмжлэгт үзүүлэх төсөл арга хэмжээ хэрэгжээгүйтэй холбоотой байна.

Тус байгууллага тайлант онд 57 орон тоотой ажиллахаас Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн 3 орон тоо дутуу ажилласан, төрийн жинхэнэ албан хаагчийн шалгалтыг зарласан боловч сул орон тоо нөхөгдөөгүй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд 2023 оны нэмэлт санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдэл 509,806.2 мянган төгрөг, Архивын ерөнхий газраас архивын ажилтны цалингийн санхүүжилт 34,361.3 мянган төгрөг, Төрийн албаны зөвлөлөөс шалгалт зохион байгуулах зардал 6,864.0 мянган төгрөг, Онцгой байдлын газраас гамшгийн бэлэн байдлын зардалд 11,155.8 мянган төгрөг, Засгийн газрын хэрэг эрхлэх гарзаас бүсийн чуулган зохион байгуулах зардал 70,868.0 мянган төгрөг, НҮБ-ын хүүхдийн сангаас хөтөлбөр төсөлд зарцуулах 53,742.5 мянган төгрөг, Хөгжлийн хөтөлбөрөөс Хурдан цахим үйлчилгээний төвийн зардалд 67,000.0 мянган төгрөг, Сангийн яамнаас Шүүх шинжилгээний бүсийн төвийн байрны засварт 245,443.4 мянган төгрөг, Шарын голын 2 дугаар сургуулийн засвар, тоног төхөөрөмжийн зардалд 9,999.0 мянган төгрөг, төрийн үйлчилгээний тоног төхөөрөмж 152,281.1 мянган төгрөг, Сонгуулийн ерөнхий хорооноос үйл ажиллагааны зардалд 766.6 мянган төгрөг, ХХААХҮЯ-аас гэрээт ажлын хөлс болон байрны тохижилтод 209,024.4 мянган төгрөг, Хаан даатгал ХХК-аас ослын даатгалд 523.5 мянган төгрөг, иргэнээс зааз бухын үнэ 862.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 928,492.4 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 406,214.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж 390,832.6 мянган төгрөгийг авлагаар тусгасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд бичиг хэргийн материал худалдан авах 20,000.0 мянган төгрөг, багаж, техник хэрэгсэл худалдан авах 20,000.0 мянган төгрөг, мэдээлэл технологийн үйлчилгээ 20,000.0 мянган төгрөг, тээврийн хэрэгслийн даатгалын үйлчилгээ 6,000.0 мянган төгрөг, шатахуун тосолгооны материал худалдан авах 65,000.0 мянган төгрөг, шуудан, холбоо, интернэтийн үйлчилгээ 20,000.0 мянга, нийт 151,000.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөгөөндөө тусгажээ. Аудитаар төлөвлөгөөний дагуу харьцуулалтын аргаар шатахуун, тосолгооны материал худалдан авах арга хэмжээг зохион байгуулаагүй зөрчил илэрлээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой худалдан авах ажиллагаатай, шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Батмягмар гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 2-10/186 дугаартай албан бичгээр 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсвийн 8,479,616.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 84,796.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 492,678.7 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 71,068.9 мянган төгрөгийн 4 гүйлгээ, зарлагын 1,078,435.3 мянган төгрөгийн 48 гүйлгээ, 151,000.0 мянган төгрөгийн тендер шалгаруулсан худалдан авах ажиллагааны 6 мэдээлэл, 499,051.2 мянган төгрөгийн 94 шийдвэрийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8-д заасны дагуу дээрх мэдээллийг нөхөж байршуулахаар, мөн алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 42,047.7 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 32,547.2 мянган төгрөгийн 4 зөвлөмж, 9,495.5 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	32,547.2	3	32,547.2	100
Төлбөрийн акт	1	9,495.5	3	9,495.5	100
Албан шаардлага	1	-	1	-	100
Нийт дүн	6	42,047.7	6	42,047.7	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,254,832.7 мянган төгрөгийн 3 алдаа¹ илрүүлж аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Өмнөх үеийн үр дүнг санхүүгийн байдлын тайланд 593,963.6 мянган төгрөгөөр илүү, өмчийн өөрчлөлтийн тайланд 2,578,365.1 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн нь УСНББОУС-1 “Санхүүгийн тайлангийн толилуулга” стандартын 53, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлтэй тус тус нийцээгүй тул санхүүгийн байдлын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайланд нийт 3,172,164.3 мянган төгрөгөөр тусгуулж залруулав.

2. Бараа материалын тайланд 19,800.0 мянган төгрөгийн шагналын энгэрийн тэмдгийг бэлэн бүтээгдэхүүний дансанд бүртгэсэн нь УСНББОУС 1, УСНББОУС 12, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”, “Толилуулга”, “Ангилал” батламж мэдэгдэлтэй тус тус нийцээгүй тул шагналын энгэрийн тэмдгийг бусад хангамжийн материал дансанд бүртгэж залруулсан.

3. Тайлант онд УТХО болон ОНХС-аар 62,704.0 мянган төгрөгийн автомашин, түр сууц, усан агаар халаагч зэрэг үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийг бүртгэлд тусгаагүй нь УСНББОУС 1, УСНББОУС 17, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”, “Иж бүрэн байх” батламж мэдэгдэлтэй тус тус нийцээгүй тул санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлого дансанд бүртгэж залруулга хийсэн.

Мөн аудитаар илэрсэн нийт 1,880,195.8 мянган төгрөгийн зөрчилд² 11,290.1 мянган төгрөгийн 4 төлбөрийн акт тогтоож, 4,350.4 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1,864,555.3 мянган төгрөгийн 2 зөвлөмж, хариуцлага тооцох 1 албан шаардлага хүргүүллээ.

5.1 Төлбөрийн акт

- Тайлант онд сахилгын шийтгэлтэй албан хаагчид ажлын үр дүнгийн урамшуулалд 1,765.2 мянган төгрөг тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоол 3 дугаар хавсралтын 2.7-д “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй”, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 9.5-д “Сахилгын шийтгэлтэйд тооцох хугацаа 1 жил байна. Энэ хугацаанд ажилтанд хөдөлмөрийн дотоод журамд заасан шагнал, урамшил олгохгүй”,

- Засаг даргын орлогчид үр дүнгийн урамшуулалд 2,263.8 мянган төгрөг давхардуулан олгож, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2-д “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна”,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- Байгууллагын 73 албан хаагчид тайлант оны 1 дүгээр улирлын ажлын үр дүнгийн урамшууллыг нэмэгдсэн цалингаас тооцож, нийт 5,061.1 мянган төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2-д “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна”,

- Тус байгууллагын гэрээт ажилтан нарт хөдөлмөрийн гэрээнд заагаагүй 2,200.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгож, төсвийг арвилан хэмнэлттэй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэж заасантай тус тус нийцээгүй тул төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

- Байгууллагын батлагдаагүй орон тоо болох бичээч, туслах архивч албан тушаалыг хавсран ажиллуулж 4,350.4 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.3-т “батлагдсан цалингийн сан орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.6-д “ажилтанд эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгэсний болон бусад нэмэгдэл хөлсний хэмжээг хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтооно” гэж заасантай нийцэхгүй байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

- Тайлант онд байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 2-10/186 дугаар албан тоотоор 02 дугаар сарын 17-ны өдөр хугацаа хоцроож ирүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д “Төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” гэж заасантай нийцээгүй тул хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж³

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд худалдан авах ажиллагаа зарлаагүйгээр шатахуун, тос тосолгооны материал 65,000.0 мянган төгрөгийн арга хэмжээг шууд гэрээ байгуулсан байна.

³ 20.5.Шалгаагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-т “Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

ТБОНӨХБАҮХА тухай хуулийг хэрэгжүүлж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулах.

Шилэн данстай холбоотой зөвлөмжийг тайлангийн 4.4.1 дэх хэсэгт тусгасан болно.

Дээрх зөвлөмжөөс гадна тайлангийн 4.4.1 дэх хэсэгт дурдсан Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй зөрчилд өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5⁴-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 10 дугаар сарын 30-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

⁴ Шалгадагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Тайлант онд тус байгууллагын Засаг даргын орлогчид үр дүнгийн урамшуулал давхардуулан олгосон	1	2,263.8	1	2,263.8																
Сахилгын шийтгэлтэй албан хаагчид ажлын үр дүнгийн урамшуулал олгосон	1	1,765.2	1	1,765.2																
Тус байгууллагын гэрээт ажилтан нарт хөдөлмөрийн гэрээнд заагаагүй үр дүнгийн урамшуулал олгосон	1	2,200.0	1	2,200.0																
Батлагдаагүй орон тоонд хавсран ажилласны нэмэгдэл олгосон	1	4,350.4			1	4,350.4														
Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагаа зарлаагүй шууд гэрээ байгуулсан байна	1	65,000.0					1	65,000.0												
Тус байгууллага нь 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 2-10/186 тоот албан бичгээр 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдөр ирүүлсэн.	1	-									1									
Дүн	7	80,640.5	4	11,290.1	1	4,350.4	2	1,864,555.3	1	1	-									

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж														
			Төлбөрийн акт		Албан шаардлага																
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн													
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил																					
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн 52 гүйлгээ, төсөв, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 94 тушаал, шийдвэр мэдээлээгүй байна.	1	1,799,555.3	-	-	-	-	1	1,799,555.3													
Дүн	1	1,799,555.3	-	-	-	-	1	1,799,555.3	1	1	-										
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил																					
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	1	1,799,555.3	-	-	-	-	1	1,799,555.3	1	1	-	1,799,555.3									

/мянган төгрөгөөр/